



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код:  
БНА-2023/107/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2023 оны 02 дугаар сарын 24</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Азбаяр Утас: 99061429      Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл  
.....
  - 4.2 Материаллаг байдал  
.....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал  
.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТАГ	Төрийн аудитын газар
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584  
Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2023.02.17 № 2/58

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

БАЯНХОНГОР АЙМГИЙН САНХҮҮГИЙН,  
ХЯНАЛТ АУДИТЫН АЛБАНЫ ТӨСВИЙН  
ЗАХИРАГЧ Л.ЖАРГАЛЦЭЦЭГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 59 арга хэмжээг хэрэгжүүлэхээр

003020274

тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 100.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны санхүүгийн тайланд толилууаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>7,020,436.00</u></b>	<b><u>3,856,700.00</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	7,020,436.00	3,856,700.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	00.00	313,500.00
35130	Эм боох материал	00.00	313,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	7,020,436.00	3,543,200.00
35410	Бичиг хэргийн материал	1,416,700.00	847,000.00
35420	Аж ахуйн материал	4,930,440.00	2,546,200.00
35440	Түлш, шатах тослох материал	673,296.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	150,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>17,173,594.62</u></b>	<b><u>11,863,535.41</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	17,173,594.62	11,863,535.41
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	17,173,594.62	11,863,535.41
39203	Авто-тээврийн хэрэгсэл	10,991,319.50	00.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-10,991,319.50	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,711,720.00	27,486,720.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-24,120,020.00	-21,183,445.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,619,820.00	13,716,520.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,087,825.38	-8,206,159.59
39217	Ном	49,900.00	49,900.00
39301	Программ хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-880,000.00	-880,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>24,194,030.62</u></b>	<b><u>15,720,235.41</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>24,194,030.62</u></b>	<b><u>15,720,235.41</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	24,194,030.62	15,720,235.41
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	24,194,030.62	15,720,235.41
51210	Өмнөх үеийн үр дүн	24,194,030.62	24,194,030.62
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-8,473,795.21
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>24,194,030.62</u></b>	<b><u>15,720,235.41</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>194,553,326.00</b>	<b>168,343,900.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>673,726.00</b>	<b>72,300.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	673,726.00	72,300.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>193,879,600.00</b>	<b>168,271,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	167,271,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	167,271,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	1,000,000.00

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	193,879,600.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	193,879,600.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>183,567,267.96</b>	<b>176,817,695.21</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>183,567,267.96</b>	<b>176,817,695.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	181,789,911.59	160,493,637.99
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	129,679,425.28	110,570,095.88
210101	Үндсэн цалин	118,644,425.28	80,096,681.88
210102	Нэмэгдэл	00.00	21,844,710.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,035,000.00	8,628,704.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	16,826,151.35	13,823,732.90
210201	Тэтгэврийн даатгал	11,562,918.75	9,401,440.17
210202	Тэтгэмжийн даатгал	1,342,400.07	1,106,051.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,038,181.56	884,841.43
210204	Ажилгүйдлийн даатгал	251,887.83	219,295.94
210205	Эрүүл мэндийн даатгал	2,630,763.14	2,212,103.57
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,061,665.00	14,754,258.00
210401	Бичиг хэрэг	2,507,200.00	1,979,600.00
210402	Тээвэр, шатахуун	8,002,030.00	8,619,596.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	758,375.00	1,770,822.00
210404	Ном, хэвлэл	330,400.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	463,660.00	2,384,240.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	200,000.00	200,000.00
210502	Хоол, хүнс	200,000.00	200,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,180,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	7,180,000.00	3,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	8,389,000.00	10,441,400.00
210702	Дотоод албан томилолт	8,389,000.00	10,441,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	839,092.00	2,394,092.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,980,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	172,092.00	130,592.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	245,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,614,577.96	5,310,059.21
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,253,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,361,577.96	5,310,059.21
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,777,356.37	16,324,057.22
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,500,000.00	1,186,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,186,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	277,356.37	15,137,557.22
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	277,356.37	15,137,557.22
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>10,986,058.04</b>	<b>-8,473,795.21</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>10,986,058.04</b>	<b>-8,473,795.21</b>

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>193,879,600.00</b>	<b>168,271,600.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>193,879,600.00</b>	<b>168,271,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	167,271,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	167,271,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	193,879,600.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	193,879,600.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>181,132,600.00</b>	<b>168,271,600.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>181,132,600.00</b>	<b>168,271,600.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>179,355,243.63</b>	<b>151,634,042.78</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	129,679,425.28	110,570,095.88
210101	Үндсэн цалин	118,644,425.28	80,096,681.88
210102	Нэмэгдэл	00.00	21,844,710.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,035,000.00	8,628,704.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	16,826,151.35	13,823,732.90
210201	Тэтгэврийн даатгал	11,562,918.75	9,401,440.17
210202	Тэтгэмжийн даатгал	1,342,400.07	1,106,051.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,038,181.56	884,841.43
210204	Ажилгүйдлийн даатгал	251,887.83	219,295.94
210205	Эрүүл мэндийн даатгал	2,630,763.14	2,212,103.57
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,773,575.00	11,204,722.00
210401	Бичиг хэрэг	2,836,900.00	1,409,900.00
210402	Тээвэр, шатахуун	8,381,600.00	7,874,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	758,375.00	1,920,822.00
210404	Ном, хэвлэл	1,997,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	799,700.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	200,000.00	200,000.00
210502	Хоол, хүнс	200,000.00	200,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,180,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	7,180,000.00	3,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	8,389,000.00	10,441,400.00
210702	Дотоод албан томилолт	8,389,000.00	10,441,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,054,092.00	2,394,092.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,980,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	172,092.00	130,592.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	460,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,253,000.00</b>	<b>00.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,253,000.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,777,356.37</b>	<b>16,637,557.22</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,500,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>277,356.37</b>	<b>15,137,557.22</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	277,356.37	15,137,557.22
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>12,747,000.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>12,747,000.00</b>	<b>00.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>12,747,000.00</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>12,747,000.00</b>	<b>00.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,747,000.00	00.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-12,747,000.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	13,207,972.58	00.00	13,207,972.58
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	7,388,726.13	00.00	7,388,726.13
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	20,596,698.71	00.00	20,596,698.71
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	20,521,224.32	00.00	20,521,224.32
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	24,194,030.62	00.00	24,194,030.62
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	24,194,030.62	00.00	24,194,030.62
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	24,194,030.62	00.00	24,194,030.62
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-8,473,795.21	00.00	-8,473,795.21
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	15,720,235.41	00.00	15,720,235.41

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	167,271,600.00	152,134,042.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	167,271,600.00	152,134,042.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	165,771,600.00	150,634,042.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	123,989,800.00	110,572,004.58
210101	Үндсэн цалин	85,428,900.00	80,098,590.58
210102	Нэмэгдэл	30,640,900.00	21,844,710.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,920,000.00	8,628,704.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,498,700.00	13,821,824.20
210201	Тэтгэврийн даатгал	10,539,100.00	9,431,321.35

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	1,239,900.00	1,097,475.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	991,900.00	878,160.40
210204	Ажилгүйдлийн даатгал	248,000.00	219,615.10
210205	Эрүүл мэндийн даатгал	2,479,800.00	2,195,251.85
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,208,000.00</b>	<b>11,204,722.00</b>
210401	Бичиг хэрэг	1,410,000.00	1,409,900.00
210402	Тээвэр, шатахуун	7,874,000.00	7,874,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,924,000.00	1,920,822.00
210502	Хоол, хүнс	200,000.00	200,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,000,000.00</b>	<b>3,000,000.00</b>
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>10,441,400.00</b>	<b>10,441,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	10,441,400.00	10,441,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,433,700.00</b>	<b>1,394,092.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	981,600.00	980,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	169,100.00	130,592.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1500000.00</b>	<b>1500000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,500,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>167,271,600.00</b>	<b>167,271,600.00</b>
131001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	167,271,600.00	167,271,600.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>09.00</b>	<b>09.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	07.00	05.00
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00
620004	Гэрээт ажилтан	02.00	02.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Эрсдэлд суурилсан дотоод аудит, хяналт шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэргэжил арга зүй, зөвлөгөө өгөх замаар төсвийн сахилга батыг сайжруулах, хариуцлагыг дээшлүүлэх, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, хараат бус бие даасан, бодитой баталгаажуулах болон зөвлөх үйлчилгээг үзүүлдэг бөгөөд санхүүгийн хяналт шалгалт дотоод аудит гэсэн хоёр чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Дотоод аудитын чиглэл нь байгууллагын үйл ажиллагааг сайжруулж, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бодитой баталгаа өгч зөвлөх үйл ажиллагаа юм. Энэ нь системтэй, оновчтой арга хандлагаар байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж, сайжруулахад туслах үүрэгтэй.

Санхүүгийн хяналт шалгалтын чиглэл нь иргэн, хуулийн этгээдийн явуулж байгаа үйл ажиллагаа /үйлдэл, эс үйлдэхүй/, түүнчлэн үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэсэн хянан шалгах арга хэмжээний цогцолбор юм.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 327 дугаар тогтоолоор санхүүгийн хяналт шалгалтын чиг үүрэг Сангийн яаманд шилжсэнтэй холбогдуулан аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Санхүүгийн хяналт шалгалтын хэлтэс нь аймгийн Засаг даргын А/680 дугаар захирамжаар 11 хүний бүтэц орон тоотойгоор Санхүүгийн хяналт, аудитын алба болж шинээр байгуулагдан үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Дотоод хяналтын ажилтан нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба 2022 оны санхүүгийн үйл ажиллагаа, дотоод ажилд удирдамж гарган дотоод хяналтыг хийж, аудитыг хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын 2021.12.15-ний өдрийн А/35 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 24,194.0 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 8,473.8 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан  
Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	7,020.4	3,865.7	(3,154.7)
Үндсэн хөрөнгө	62,252.8	42,133.1	(20,119.6)
	(45,079.2)	(30,269.6)	14,809.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>24,194.0</b>	<b>15,720.2</b>	<b>(8,473.8)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	<b>24,194.0</b>	<b>15,720.2</b>	<b>(8,473.8)</b>
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>24,194.0</b>	<b>15,720.2</b>	<b>(8,473.8)</b>

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Авлага, өглөгийн дансны үлдэгдэлгүй тайлант оны эхэнд болон тайлант онд өр авлагагүй ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,865.7 мянган төгрөг болж өмнөх оноос 3,154.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлан онд төсвийн хөрөнгөөр 13,789.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, шаардах хуудсаар зарцуулсан бараа материал 14,735.6 мянган төгрөг, акталж, устгасан нь 1,145.0 мянган төгрөгийн хөрөнгийг албаны Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн шийдвэрээр акталж устгасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 62,252.8 мянган төгрөг болж 20,119.6 мянган төгрөгөөр буурсан нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн 2022 оны Б/025 дугаар тогтоолоор Жинст сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд 10,991.3 мянган төгрөгийн үнэ бүхийн 0027БНА улсын дугаартай Lexus-470 авто машиныг шилжүүлж, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны Б/26 дугаар тоног төхөөрөмж 6,225.0 мянган төгрөг, тавилга хэрэгслээс 2,903.3 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж акталж устгасантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 24,194.0 мянган төгрөг болж 15,720.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 8,473.8 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 343,231.7 мянга, нийт зарлагыг 343,231.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 166,928.4 мянган төгрөгөөр бууруулж 167,271.6 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор ямар нэгэн төсөв нэмэгдүүлэн баталсан зүйл байхгүй байна Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 70106 хөтөлбөрийн 80801, 80802 арга хэмжээг санхүүжүүлэхээр 167,271,600.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 167,271,600.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 167,271,600.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, зарцуулагдаагүй 15,137.6 мянган төгрөгийг буцаан төвлүүлэх шилжүүлэг хийж орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 152,134,0 мянган төгрөг буюу 91.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 15,137.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/
Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 үндсэн үйл ажиллагааны зардал	167,271.6	150,634.0	15,137.6	91.0
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	1,500.0	1,500.0	0.0	100.0
	Нийт дүн	165,771.6	152,134.0	15,137.6	95.5

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн 10003005107 тоот дансанд 1,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зарцуулсан байна.

Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого

		/төгрөгөөр/
д/д	Орлогын төрөл	Авсан санхүүжилт
1	Аймгийн Засаг даргын А/02 захирамжаар хяналт шинжилгээ үнэлгээний урамшуулал	1,000.0
	НИЙТ ДҮН	1,000.0

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Санхүүгийн хяналт шалгалт аудитын албаны дарга нь аймгийн Засаг даргаар албаны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, Монгол Улсын Засгийн газрын Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын зарим чиг үүргийг хөдөө орон нутагт төлөөлөн хэрэгжүүлж, аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын А/286 дугаар захирамжийн хавсралт “Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам шинэчлэн батлах тухай журам”-ын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа тайлагнан ажилласан байна.

Уг журмын 10 дугаар зүйлийн 10.2.4 дахь хэсэгт заасан ажлын үр дүнгэрээ “Тусгай байр эзэлсэн” 2 агентлагийн нэгээр шалгарч 1,000.0 мянган төгрөгийн урамшуулал авч, тус санхүүжилтийг ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор ажилтан, албан хаагчдыг Улаанбаатар хотод Интермэд эмнэлэгт нэгдсэн нарийн шинжилгээнд хамруулан, албаны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралтаар баталсан Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж 2022 оны 04 дүгээр сард 1,000.0 мянган төгрөгийн орлого орж ирснийг тухайн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан  
Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

№	Хөтөл бөр	Эдийн засгийн ангилал	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106-80101	210101-210103	2022.01.01-2022.12.31	Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын дагуу Төрийн төрийн захиргаа 8 алба хаагч, төрийн үйлчилгээний 6 алба хаагч, нийт 14 алба хаагчийн 1-12 дугаар сарын цалинг бодож олгосон.	89.2%	123,989,800.00	110,572,004.58
		210201-210205	2022.01.01-2022.12.31	Алба хаагчдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээ тайланг сар бүр төлж, өр авлагагүй ажилласан.	89.2%	15,498,700.00	13,821,824.20
		210401	2022.01.01-2022.12.31	Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны албан хаагчдыг бичиг хэргийн материалаар хангаж, зардлыг 100 хувь шилжүүлсэн.	100%	1,410,000.0	1,409,900.0
		210402	2022.01.01-2022.12.31	Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын ажлыг хийж гүйцэтгэхэд зарцуулсан тээвэр шатахуун зардлыг 100 хувь шилжүүлсэн.	100%	7,874,000.00	7,874,000.00
		210403	2022.01.01-2022.12.31	Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны шуудан холбоо, интернэтийн төлбөрийг 100 хувь төлж барагдуулан харилцаа холбооны зардлыг 100 хувь шилжүүлсэн.	100%	1,924,000.00	1,920,822.00
		210502	2022.01.01-2022.12.31	Аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын хорооны гишүүдийн хоолны зардлыг 100 хувь төлж барагдуулсан.	100%	200,000.00	200,000.00
		210604	2022.01.01-2022.12.31	Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын албаны ажилтан, албан хаагчдын өрөө тасалгааны урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэн ажиллах нөхцөл боломжоор хангасан.	100%	3,000,000.00	3,000,000.00
		210702	2022.01.01-2022.12.31	Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын ажлыг хийж гүйцэтгэхэд зарцуулсан дотоод албан томилолтын тооцоог албан хаагч бүртэй хийж зардлыг 100 хувь шилжүүлсэн	100%	10,441,400.00	10,441,400.00
		210801	2022.01.01-2022.12.31	Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын ажлыг хийж гүйцэтгэхэд ашигладаг албан хаагчдын компьютерын вирусний программ суулгах, шинэ үйлдлийн системийг суулгахаар иргэн Д.Энхбадрахтай ажил гүйцэтгэх гэрээг хийж, үйлчилгээг авч ажлын хөлсийг бүрэн шилжүүлж, Санхүүгийн тооцоолох программын лицензийн төлбөрийг төлж программыг хэвийн ажиллагаанд оруулж зардлыг 100 хувь шилжүүлсэн.	99.9%	981,600.00	980,500.00

**Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

		210802	2022.01.01- 2022.12.31	Баянхонгор аймаг Төрийн аудитын газраас аудит ба зэрэглэл тогтоох үйлчилгээг авч зардлыг 100 хувь шилжүүлсэн.	100%	250,000.00	250,000.00
		210804	2022.01.01- 2022.12.31	Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байсан 0027БНА авто машиныг 2022 оны албан татварыг 100 хувь шилжүүлж, Орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгсөн.	77.2%	169,100.00	130,592.00
		210805	2022.01.01- 2022.12.31	Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байсан 0027БНА авто машиныг 2022 оны авто тээврийн оношилгооны төлбөрийг 100 хувь шилжүүлж, Орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгсөн.	100%	33,000.00	33,000.00
70106- 80802	213209		2022.01.01- 2022.12.31	Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Д.Мөнхханд, Б.Бат-Эрдэнэ, Аудитор О.Бямбасүрэн, Л.Оюундэлгэр, О.Отгонбаяр нарын ар гэрт нь гачигдал тохиолдсон тул албаны даргын тушаалаар нэг буцалтгүй тэтгэмжийг шилжүүлсэн. Албан хаагчдыг Улаанбаатар хотруу нарийн шинжилгээнд хамруулахад зарцуулсан.	100%	1,500,000.00	1,500,000.00

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга Л.Жаргалцэцэг, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч О.Отгонбаяр нар зурж байна.

#### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 176,817.7 мянган төгрөгөөс 1,768.2 мянган төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 1,237.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаарлалт үйлчлэхгүй бөгөөд бусад хэмнэлттэй холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2022 онд нийт 1,388,291.2 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас иж бүрэн мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	0
3	Улирал бүр	1	4	4	0	0
4	Сар бүр	3	36	36	0	0
5	Тухай бүр	8	96	96	0	0
6	Нийт	27	151	149	0	2

Аудитаар тендер шалгаруулах худалдан авах ажиллагаа-1, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 167,271.6 мянган төгрөгийн 12 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой төгрөгийн 29 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой 1 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн ба Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын 2022.05.30-ны өдрийн 40 дүгээр албан бичгээр хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	0	1	0	100
Нийт дүн	1	0	1	0	100

##### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

-oOo-